АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Архангай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2022/29/-НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Архангай аймаг<br>2022 он | Дарга,Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа<br>Утас:7033-3141<br>Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn<br><br>Аудитын менежер Д.Нэргүйбаатар<br>Утас: 7033-2860<br>Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn<br><br>Аудитор П.Цэцэгдулам<br>Цахим хаяг: Tsetsegdulamp@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

1.Аудитын санал, дүгнэлт
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ..... 2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 7
3. Аудитын тайлан ..... 9
3.1 Ерөнхий зүйл ..... 12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ..... 12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 13
3.4 Материаллаг байдал ..... 13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ..... 13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..... 14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ..... 14
3.8 Аудитын гол асуудал ..... 15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..... 15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 16
4. Аудитын илрүүлэлт ..... 16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ..... 17

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ШШГЕГ | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар |

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс:976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2022.02.25 № 97

танай ______________-ны № ________________-т

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗРЫН ДАРГА, ХУРАНДАА Д.ТУЛГА ТАНАА

Аудитын санал дүгнэлт

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.БАЙГАЛМАА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2021.12.31-ний өдрөөр дуусгавар болсон* *\/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 38,173,169.96 | 47,987,120.94 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 38,173,169.96 | 47,987,120.94 |
| 35100 | Түүхий эд материал | 13,801,815.51 | 23,251,781.10 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 12,545,211.00 | 21,739,441.00 |
| 35130 | Эм боох материал | 1,256,604.51 | 1,512,340.10 |
| 35400 | Хангамжийн материал | 24,371,354.45 | 24,735,339.84 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,971,979.50 | 3,185,696.82 |
| 35420 | Аж ахуйн материал | 18,930,374.95 | 19,208,669.95 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 940,000.00 | 940,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 547,500.00 | 0 |
| 35450 | Барилгын засварын материал | 910,000.00 | 910,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 71,500.00 | 490,973.07 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,086,013,480.52 | 1,057,703,023.76 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,086,013,480.52 | 1,057,703,023.76 |
| 39200 | Биет хөрөнгө | 991,944,941.97 | 961,079,023.67 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,119,425,980.00 | 992,993,980.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -233,049,159.80 | -140,469,504.48 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 153,621,630.88 | 153,621,630.88 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -108,294,547.52 | -121,819,547.36 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 103,872,007.25 | 117,816,004.80 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -69,526,862.13 | -63,188,728.30 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 35,590,103.00 | 35,590,103.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -15,987,030.07 | -19,634,939.91 |
| 39211 | Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж | 5,556,887.00 | 5,500,000.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 867,750.00 | 867,750.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -131,816.64 | -197,724.96 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 94,068,538.55 | 96,624,000.09 |
| 39301 | Програм хангамж | 6,417,692.31 | 6,417,692.31 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -5,199,153.76 | -2,643,692.22 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 92,850,000.00 | 92,850,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 1,124,186,650.48 | 1,105,690,144.70 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 1,124,186,650.48 | 1,105,690,144.70 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,124,186,650.48 | 1,105,690,144.70 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 204,847,946.70 | 204,847,946.70 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 748,034,506.11 | 767,289,200.33 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 748,034,506.11 | 785,785,706.11 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | -18,496,505.78 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 171,304,197.67 | 133,552,997.67 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 1,124,186,650.48 | 1,105,690,144.70 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */ төгрөгөөр /*

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 676,107,200.00 | 693,362,340.10 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 29,322,800.00 | 63,276,140.10 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 29,322,800.00 | 63,276,140.10 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,386,342.00 | 19,365,162.10 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 25,000.00 | 35,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 1,361,342.00 | 19,330,162.10 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 19,290,000.00 | 30,192,900.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 8,646,458.00 | 13,718,078.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 646,784,400.00 | 630,086,200.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 638,784,400.00 | 626,261,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 638,784,400.00 | 626,261,600.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 8,000,000.00 | 3,824,600.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 8,000,000.00 | 3,605,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0 | 219,600.00 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 714,416,685.54 | 707,236,158.88 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 714,416,685.54 | 707,236,158.88 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 711,832,777.67 | 705,282,787.86 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 468,992,670.00 | 477,928,900.00 |
| 210101 | Үндсэн цалин | 290,975,700.00 | 317,844,983.96 |
| 210102 | Нэмэгдэл | 174,516,970.00 | 158,499,916.04 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,000,000.00 | 1,188,000.00 |
| 210104 | Урамшуулал | 2,500,000.00 | 396,000.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 9,562,722.13 | 9,652,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,562,722.13 | 9,652,600.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 86,623,200.00 | 88,332,150.98 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 12,172,700.00 | 12,294,582.98 |
| 210302 | Түлш, халаалт | 66,000,000.00 | 65,976,768.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 8,450,500.00 | 10,060,800.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 27,558,785.00 | 22,883,315.68 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,645,565.00 | 5,143,858.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9,732,500.00 | 8,258,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,609,300.00 | 3,251,260.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 148,000.00 | 0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,327,885.00 | 2,223,700.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 3,095,535.00 | 4,005,997.68 |
| 2105 | Нормативт зардал | 40,286,855.53 | 26,046,549.34 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,417,975.49 | 603,074.41 |
| 210502 | Хоол, хүнс | 36,606,715.64 | 24,925,734.93 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,262,164.40 | 517,740.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 10,830,000.00 | 5,138,600.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 0 | 1,520,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 0 | 152,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 10,830,000.00 | 3,466,600.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,472,000.00 | 0 |

| | | | |
|---|---|---|---|
| 210702 | Дотоод албан томилолт | 1,472,000.00 | 0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,246,200.00 | 5,322,978.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,213,700.00 | 3,820,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 400,000.00 | 0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 401,000.00 | 362,078.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 88,000.00 | 88,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 923,500.00 | 818,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 220,000.00 | 233,900.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 62,260,345.01 | 69,977,693.86 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 963,000.00 | 756,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 500,000.00 | 0 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 60,797,345.01 | 69,221,693.86 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 2,583,907.87 | 1,953,371.02 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 253,800.00 | 210,000.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 253,800.00 | 210,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 2,305,000.00 | 1,680,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,305,000.00 | 1,680,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 25,107.87 | 63,371.02 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 25,107.87 | 63,371.02 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | -38,309,485.54 | -13,873,818.78 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 0 | 4,622,687.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | 0 | 4,622,687.00 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | -38,309,485.54 | -18,496,505.78 |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */ төгрөгөөр /*

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 204,847,946.70 | 171,304,197.67 | 786,343,991.65 | 1,162,496,136.02 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 204,847,946.70 | 171,304,197.67 | 786,343,991.65 | 1,162,496,136.02 |
| 4 | Тайлант үеийн үр дүн | 0 | 0 | -38,309,485.54 | -38,309,485.54 |
| 5 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 204,847,946.70 | 171,304,197.67 | 748,034,506.11 | 1,124,186,650.48 |
| 6 | 2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 204,847,946.70 | 171,304,197.67 | 748,034,506.11 | 1,124,186,650.48 |
| 7 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0 | 0 | 37,751,200.00 | 37,751,200.00 |
| 8 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 204,847,946.70 | 171,304,197.67 | 785,785,706.11 | 1,161,937,850.48 |
| 9 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0 | -37,751,200.00 | 0 | -37,751,200.00 |
| 10 | Тайлант үеийн үр дүн | 0 | 0 | -18,496,505.78 | -18,496,505.78 |
| 11 | 2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 204,847,946.70 | 133,552,997.67 | 767,289,200.33 | 1,105,690,144.70 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *( төгрөгөөр )*

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 646,809,400.00 | 630,121,200.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 25,000.00 | 35,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 25,000.00 | 35,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 25,000.00 | 35,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 25,000.00 | 35,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 646,784,400.00 | 630,086,200.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 638,784,400.00 | 626,261,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 638,784,400.00 | 626,261,600.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 8,000,000.00 | 3,824,600.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 8,000,000.00 | 3,605,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0 | 219,600.00 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 645,402,345.00 | 630,121,200.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 645,402,345.00 | 630,121,200.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 642,818,437.13 | 628,167,828.98 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 468,992,670.00 | 477,928,900.00 |
| 210101 | Үндсэн цалин | 290,975,700.00 | 317,844,983.96 |
| 210102 | Нэмэгдэл | 174,516,970.00 | 158,499,916.04 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,000,000.00 | 1,188,000.00 |
| 210104 | Урамшуулал | 2,500,000.00 | 396,000.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 9,562,722.13 | 9,652,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,562,722.13 | 9,652,600.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 86,623,200.00 | 88,332,150.98 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 12,172,700.00 | 12,294,582.98 |
| 210302 | Түлш, халаалт | 66,000,000.00 | 65,976,768.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 8,450,500.00 | 10,060,800.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 24,894,600.00 | 18,288,700.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,628,800.00 | 4,815,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10,280,000.00 | 7,711,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,609,300.00 | 3,251,260.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 148,000.00 | 0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,228,500.00 | 2,510,940.00 |
| 2105 | Нормативт зардал | 34,283,100.00 | 22,367,900.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 759,100.00 | 657,900.00 |
| 210502 | Хоол, хүнс | 33,524,000.00 | 21,710,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 11,280,945.00 | 5,518,600.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 668,000.00 | 1,800,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 190,000.00 | 252,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 10,422,945.00 | 3,466,600.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,472,000.00 | 0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,472,000.00 | 0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,246,200.00 | 5,322,978.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,213,700.00 | 3,820,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 400,000.00 | 0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 401,000.00 | 362,078.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 88,000.00 | 88,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 923,500.00 | 818,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 220,000.00 | 233,900.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,463,000.00 | 756,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 963,000.00 | 756,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 500,000.00 | 0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 2,583,907.87 | 1,953,371.02 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 253,800.00 | 210,000.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 253,800.00 | 210,000.00 |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | 0 | 0 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 2,305,000.00 | 1,680,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,305,000.00 | 1,680,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 25,107.87 | 63,371.02 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 25,107.87 | 63,371.02 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 1,407,055.00 | 0 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 1,407,055.00 | 0 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 1,407,055.00 | 0 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 1,407,055.00 | 0 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 1,407,055.00 | 0 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -1,407,055.00 | 0 |

### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */ төгрөгөөр /*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 626,296,600.00 | 626,233,228.98 | 63,371.02 | 99.99 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 626,296,600.00 | 626,233,228.98 | 63,371.02 | 99.99 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 624,360,600.00 | 624,343,228.98 | 17,371.02 | 100.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 477,928,900.00 | 477,928,900.00 | 0.00 | 100.00 |
| 210101 | Үндсэн цалин | 318,277,900.00 | 317,844,983.96 | 432,916.04 | 99.86 |
| 210102 | Нэмэгдэл | 158,067,000.00 | 158,499,916.04 | -432,916.04 | 100.27 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,188,000.00 | 1,188,000.00 | 0.00 | 100.00 |
| 210104 | Урамшуулал | 396,000.00 | 396,000.00 | 0.00 | 100.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 9,652,600.00 | 9,652,600.00 | 0.00 | 100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,652,600.00 | 9,652,600.00 | 0.00 | 100.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 88,349,500.00 | 88,332,150.98 | 17,349.02 | 99.98 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 12,311,900.00 | 12,294,582.98 | 17,317.02 | 99.86 |
| 210302 | Түлш, халаалт | 65,976,800.00 | 65,976,768.00 | 32.00 | 100.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 10,060,800.00 | 10,060,800.00 | 0.00 | 100.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 15,964,100.00 | 15,964,100.00 | 0.00 | 100.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,136,000.00 | 2,710,500.00 | -574,500.00 | 126.90 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,062,900.00 | 7,491,400.00 | 571,500.00 | 92.91 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,313,400.00 | 3,251,260.00 | 62,140.00 | 98.12 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,451,800.00 | 2,510,940.00 | -59,140.00 | 102.41 |
| 2105 | Нормативт зардал | 22,367,900.00 | 22,367,900.00 | 0.00 | 100.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 657,900.00 | 657,900.00 | 0.00 | 100.00 |
| 210502 | Хоол, хүнс | 21,710,000.00 | 21,710,000.00 | 0.00 | 100.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,518,600.00 | 5,518,600.00 | 0.00 | 100.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,800,000.00 | 1,800,000.00 | 0.00 | 100.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 252,000.00 | 252,000.00 | 0.00 | 100.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,466,600.00 | 3,466,600.00 | 0.00 | 100.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,823,000.00 | 3,822,978.00 | 22.00 | 100.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,320,500.00 | 2,320,500.00 | 0.00 | 100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 362,100.00 | 362,078.00 | 22.00 | 99.99 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 88,000.00 | 88,000.00 | 0.00 | 100.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 818,500.00 | 818,500.00 | 0.00 | 100.00 |
| 210807 | Газрын төлбөр | 233,900.00 | 233,900.00 | 0.00 | 100.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 756,000.00 | 756,000.00 | 0.00 | 100.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 756,000.00 | 756,000.00 | 0.00 | 100.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,936,000.00 | 1,890,000.00 | 46,000.00 | 97.62 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 256,000.00 | 210,000.00 | 46,000.00 | 82.03 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 256,000.00 | 210,000.00 | 46,000.00 | 82.03 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,680,000.00 | 1,680,000.00 | 0.00 | 100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,680,000.00 | 1,680,000.00 | 0.00 | 100.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 626,296,600.00 | 626,233,228.98 | 63,371.02 | 99.99 |
| 31 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 626,261,600.00 | 626,198,228.98 | 63,371.02 | 99.99 |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 626,261,600.00 | 626,198,228.98 | 63,371.02 | 99.99 |
| 35 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 35,000.00 | 35,000.00 | 0.00 | 100.00 |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 35,000.00 | 35,000.00 | 0.00 | 100.00 |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1 | 1 | 0.00 | 100.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | 0.00 | 100.00 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 33 | 33 | 0.00 | 100.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | 0.00 | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 30 | 29 | 1.00 | 96.67 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 2 | 2 | 0.00 | 100.00 |

## 2.5 Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */ төгрөгөөр /*

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 3,824,600.00 |
| II | НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН | 3,824,600.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 3,824,600.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,824,600.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 2,324,600.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,105,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 219,600.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,500,000.00 |
| 210801 | Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,500,000.00 |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 3,824,600.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 3,824,600.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,605,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 219,600.00 |

## 3. Аудитын тайлан
### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Архангай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Цэцэгдулам гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.
Архангай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн 01/130 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт
Архангай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь Шүүхийн шийдвэрийг биелүүлэх чиг үүрэг бүхий Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа улсын төсвийн байгууллага байна.

Тус байгууллага нь тайлант онд “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд технологийн дэвшлийг нэвтрүүлж, албаны бэлэн байдал, сахилга хариуцлагыг дээшлүүлэх жил” гэсэн зорилт тавин ажилласан байна.
Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагын шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хяналт-шинжилгээ, дотоод аудитын хэлтсээс хяналт хийж зөвлөмж өгч ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккурэль сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу хөтөлбөр, арга хэмжээгээр бэлтгэж, тайлбар танилцуулгын хамт ирүүлсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.
Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 626.2 сая төгрөгөөс 1 хувиар буюу 6.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 4.3 сая төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөлтийн шатанд 2021 оны батлагдсан төсвөөс материаллаг байдлын суурь үзүүлэлтийг сонгож баталгаажуулсан бөгөөд гүйцэтгэлийн шатанд батлагдсан төсөвт өөрчлөлт ороогүй тул материаллаг байдлын суурь үзүүлэлтийг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 18.5 сая төгрөгөөр буурсан материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүү байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт | хувь |
|---|---|---|---|---|
| Бараа материал | 38.2 | 48.0 | 9.8 | 25.6 |
| Үндсэн хөрөнгө | 1.086.0 | 1.057.7 | - 28.3 | -2.6 |
| **Нийт хөрөнгө** | **1.124.2** | **1.105.7** | **-18.4** | -1.6 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1.124.2 | 1.105.7 | -18.4 | -1.6 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **1.124.2** | **1.105.7** | **-18.4** | -1.6 |

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Бараа материал эхний үлдэгдлээс 9.8 сая төгрөгөөр өссөн байна.

Бараа материалын данс нь 38.2 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 44.8 сая төгрөг, шилжүүлэн авсан 17.7 нийт 62.5 сая төгрөгөөр нэмэгдэж, 48.7 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, 4.0 сая төгрөгийн бараа материал акталж оны эцэст 48.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгө эхний үлдэгдлээс 28.3 сая мөгөөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс нь 1.086.0 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас үнэ төлбөргүй 30.2 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан 69.2 сая төгрөгийн элэгдэл, актлагдсан

142.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө 4.2 сая төгрөгийн гарзаар тус тус буурч 1057.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүнтэй шууд холбоотой бөгөөд тайлант хугацаанд 18.4 сая төгрөгийн үр дүнг хүлээн зөвшөөрсөн байна.

*Хүснэгт 2.* Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

| Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН | |
|---|---|---|---|
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 0.03 | 0.04 | 0.01 |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 29.30 | 63.24 | 33.94 |
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 638.78 | 626.26 | -12.52 |
| Нэмэлт санхүүжилтийн орлого | 8.00 | 3.82 | -4.18 |
| **Үйл ажиллагааны орлого** | **676.1** | **693.3** | |
| Цалин шимтгэлийн зардал | 478.56 | 487.58 | 9.03 |
| Бараа ажил үйлчилгээний зардал | 166.77 | 142.40 | -24.37 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4.25 | 5.32 | 1.08 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 62.26 | 69.98 | 7.72 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 2.58 | 1.95 | -0.63 |
| **Үйл ажиллагааны зардал** | **714.4** | **707.2** | |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | -38.3 | -18.4 | -19.8 |

Архангай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны орлого өмнөх оноос 17.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд үнэ төлбөргүй хүлээн авсан орлого өссөнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 645.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 30.5 сая төгрөгөөр бууруулж нийт зардлыг 615.1 сая төгрөгөөр хянаж баталсан бол тодотголоор батлагдсан төсөвт 11.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 626.3 сая төгрөгөөр болсон байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагч 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 626.3 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 626.3 сая төгрөгийн санхүүжилт ирж 100 хувийн гүйцэтгэлтэй байна. Тайлант онд 626.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын санхүүжилт 3.6 сая төгрөг,

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас өршөөлөөр суллагдсан хоригдлыг харъяа орон нутагт хүргэх шатахууны зардалд 0.2 сая төгрөг нийт 3.8 сая төгрөг ирсэн байна. Ирсэн санхүүжилтийг зарцуулах эрхийн хүсэлт нээлгэн зарцуулсан бөгөөд бичиг хэрэгт 2.1 сая, тээвэр шатахуунд 0.2 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд  1.5 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд орчин цагийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага үүсэн байгуулагдсаны 100 жил, Архангай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 30 жилийн ой тохиосон байна.

ШШГЕГ-ын даргын 2021.07.08-ний өдрийн А/110 дугаар “Өршөөл үзүүлэх тухай” хуульд хамрагдан суллагдагсдыг харъяа орон нутагт хүргэх тухай тушаалын дагуу Архангай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас 9 хүнийг хүргэхэд шатахууны зардалд 0.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 7 үндсэн зорилтын хүрээнд 77 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга  хэмжээний хэрэгжилт 96.0 хувьтай байна.

Тайлант онд  хэрэгжүүлэх  хөтөлбөр, арга хэмжээнд 626.3 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс хэрэгжилт 99.9 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэлэхэд Үүнд:

- Тус байгууллага нь үндсэн орон тооны 3 жолоочтой бөгөөд цалингийн зардалд 38.2 сая төгрөг олгосон байна. Тус байгууллага нь нийт УАЗ-Фургон маркийн автомашин 2, сая төгрөгийн балансын үнэ бүхий Prius маркийн автомашин 1-ийг цагдан хорих болон эрүү, иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд ашигладаг бөгөөд  шатахууны зардалд 5.5 сая төгрөг зарцуулсан байна. Тайлан онд шинээр худалдан авсан болон данс бүртгэлээс хассан автомашин байхгүй байна.

Харин бусад судалгаанд хамаарах мэдээлэлгүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.
Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжууллаа. /Local.audit.mn сайтад шивсэн/

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга,

нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Архангай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 144 мэдээллийг хугацаанд нь, 5 мэдээллийг хугацаа хоцроож, өмч хөрөнгө мөнгө зарцуулах 11 тушаал шийдвэрийг байршуулсан байна. Харин Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хяналт-шинжилгээ дотоод аудитын хэлтсээс хугацаа хоцорсон 5 мэдээлэлд зөвлөмж ирүүлж хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэж байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд зөвлөмж өгөгдөөгүй болно.

### 3.9 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хоол хүнсний зарцуулалтыг авч үзэх нь зүйтэй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилтэй асуудал илрээгүй болно. Иймд Зөрчилгүй дүгнэлт өглөө.

---oOo---

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

<table>
<tr><td rowspan="3">д/д</td><td rowspan="3">Аудитад хамрагдсан байгууллагын нэр</td><td colspan="2" rowspan="2">Нийт алдаа, зөрчлийн</td><td colspan="8">Үүнээс</td></tr>
<tr><td colspan="2">Залруулга</td><td colspan="2">Төлбөрийн акт</td><td colspan="2">Албан шаардлага</td><td colspan="2">Зөвлөмж</td></tr>
<tr><td>Тоо</td><td>Дүн</td><td>Тоо</td><td>Дүн</td><td>Тоо</td><td>Дүн</td><td>Тоо</td><td>Дүн</td><td>Тоо</td><td>Дүн</td></tr>
<tr><td colspan="12">Санхүүгийн тайлангийн аудитын асуудал</td></tr>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td colspan="2">дүн</td><td>0</td><td>0</td><td>0</td><td>0</td><td>0</td><td>0</td><td>0</td><td>0</td><td>0</td><td>0</td></tr>
<tr><td></td><td colspan="11">Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</td></tr>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td colspan="2">дүн</td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td colspan="2">Нийт дүн</td><td>0</td><td>0</td><td>0</td><td>0</td><td>0</td><td>0</td><td>0</td><td>0</td><td>0</td><td>0</td></tr>
</table>